

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

Тайланг хянасан:

Төсвийн Төвлөрүүлэн захирагч

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

.....
(гарын үсэг)

Тэмдэг

Б.БАТЖАРГАЛ

.....
(огноо)

Тайлагнасан:

Төсвийн шууд захирагч

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

.....
(гарын үсэг)

Б.АРИУНБОЛД

.....
(огноо)

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Зорилт 1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1.	Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга) болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Шаардлагагүй	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжүүлэхтэй холбоотой дээд шатны байгууллагаас 15 заавар, аргачлал, 1 зөвлөмж ирүүлснийг хүлээн авч, тухай бүр хариуцсан албан хаагчдад танилцуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу ажилласан жилийг дундаж цалингаас 1.5% өөрчлөн тогтоож байна. “Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам”, “Тэтгэвэр бодох заавар”, “Өндөр насны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар”, “Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох маягтын загвар”-ын дагуу 2109 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.	100
1.2.	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн	Тухайн аймаг, дүүргийн ҮА-ны зардлын төсөв	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг	Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 2,484.0 сая	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	Энэ онд газрын үйл ажиллагааны зардалд 2,134.1 сая төгрөг батлагдаж 2,086.3 сая төгрөгийн зардлыг ангилалын дагуу зарцуулсан ба хэмнэлтийн тухай хуулийн дагуу 47.7 сая төгрөгийг хэмнэж ажилласан. Үүнээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 1,734.0	100

	нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах;		зарцуулсан байна.	төгрөг зарцуулсан.		сая төгрөг батлагдсанаас 1,734.0 сая төгрөг, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 206.8 сая төгрөг зарцуулахаас 206.8 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 55.7 сая төгрөг батлагдсанаас 41.2 сая төгрөгийг тус тус зарцуулж, 14.5 сая төгрөгийг, ЭММЗ-ийн цалин урамшуулал 108,8 сая төгрөг зарцуулахаас 77,8 сая төгрөг зарцуулж, 31,0 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 21,9 сая төгрөг батлагдсанаас 20,5 сая төгрөгийг зарцуулж 1,4 сая төгрөгийг, эд хогшил, урсгал засварын зардалд 1,1 сая төгрөг зарцуулахаас 0.3 сая төгрөгийг зарцуулж 0.7 сая төгрөгийг тус тус хэмнэсэн. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 3,6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 0.2 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулалд 1,5 сая төгрөгийг тус тус бүрэн зарцуулсан.	
1.3.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах;	15 сая	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг батлагдсан төсвийн дагуу ажилласан.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрсдэл өндөр ажил олгогчдод Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл зөвлөгөө өгөх сургалтыг газрын даргын А/09 тушаалаар комисс байгуулж, сургалт явуулах зөвшөөрөлтэй мэргэжлийн “Арш хур” ХХК-тай хамтран 9,8 сая төгрөгийн санхүүжилтээр 3 байгууллагын 67 хүнийг хамруулан мэдлэгийг дээшлүүлсэн.	100

1.4.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;	-	2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна.	-	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна.	Газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын дагуу нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирсэн иргэд, даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, 9 асуулт бүхий судалгааг авч үр дүнг тооцон тайланг НДЕГ-ын Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газарт хүргүүлсэн. Судалгаанд 600 орчим иргэн хамрагдаж, тэдний үйлчилгээний сэтгэл ханамж дараах байдлаар үнэлэгдсэн байна. Хангалттай - 82,1% буюу 4 оноо, ойлгомжгүй - 10,7% буюу 2 оноо, хангалтгүй - 7,1% буюу 1 оноотой дүгнэгдсэн. Энэхүү ажлын хүрээнд үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагч, ажил олгогч байгууллагуудад холбогдох мэдээ мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх, чиглүүлэх, зөвлөгөө өгөх, хяналт тавих чиг үүрэг бүхий "Хөтөч байцаагч"-г 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр томилон ажиллуулж байна. Ингэснээр тус газраас үйлчилгээ авахаар ирсэн иргэд даатгуулагчид аль цонхноос ямар үйлчилгээ авахаас эхлээд шаардлагатай баримт бичгийн жагсаалт, өргөдөл, санал хүсэлт гээд олон асуудлыг нэг дор шийдвэрлүүлэх боломжтой болж, сэтгэл ханамжтай үйлчлүүлсэн иргэдээс талархал бичиж үлдээх болсон нь хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн гарч байна.	
------	---	---	--	---	---	---	--

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Зорилт 2: “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдээдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

2.1.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.		НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.	Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 580,317.6 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн.	НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.	НДЕГ-ын даргын 2025.11.19-ны өдрийн А/320 дугаар тушаалаар төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр төвлөрүүлэлтэд нийт 550,568.51 сая төгрөг бүрэн төвлөрүүлсэн байна. Энэ онд тэтгэврийн санд 257,450.5 сая төгрөг, тэтгэмжийн санд 22909.4 сая төгрөг, ҮОМШӨСанд 2380.9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 18,611.3 сая төгрөг нийт 301,352.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч үйлчилгээг тасралтгүй явуулж ажиллалаа.	100
2.2.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. б) Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн байна. в) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна.	НДЕГ-ын даргын 2025 оны 11 сарын 19-ний өдрийн А/320 дугаар тушаалын дагуу тэтгэврийн даатгалын санд 422663.3 сая төгрөг зарцуулахаас 420,873.6 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 24167.4 сая төгрөг зарцуулахаас 25275.34 сая төгрөг, ҮОМШӨ-ний тэтгэвэр тэтгэмжинд 3298.4 сая төгрөг зарцуулахаас 2264.3 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 18613.6 сая төгрөг зарцуулахаас 20,822.20 сая төгрөг зарцуулсан. Ажилгүйдлийн тэтгэмжийн санд шаардлагатай байгаа мөнгөн хөрөнгийн тооцоог НДЕГ-ын БХТГазарт албан бичгээр хүргүүлсэн. СДД дээр 3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс олгохоор шийдвэрлэсэн хуулийн хүрээнд гэрээ байгуулсан эхчүүдэд тэтгэмжийн даатгалын сангаас 482.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн орлогод төвлөрүүлэн ажилласан.	100
2.3.	Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж,		Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн	Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулсан.	а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.	Газрын үйл ажиллагааны зардалд 2,134.1 сая төгрөг батлагдаж 2,086.3 сая төгрөгийн зардлыг ангилалын дагуу зарцуулсан ба хэмнэлтийн тухай хуулийн	100

	хэмнэлтийн зарчмыг баримтлах.		ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана.		б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна.	дагуу 47.7 сая төгрөгийг хэмнэж ажилласан. Байгууллагын үйл ажиллагааны зардалд 2,086.3 сая төгрөгийн төсвийг зардлын ангилалын дагуу зарцуулсан. Тус газар нь ажиллагсадтай холбоотой болон аж ахуйн нэгж байгууллагад өр авлага үүсгээгүй болно.	
2.4.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах		Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цагалбарын дагуу Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн мэдээ тайлангуудыг тус тус боловсруулан хугацаанд нь НДЕГ-ын СБХОГазарт тайлагнасан. Сангийн хамрагдалт, орлого, зарлагын мэдээг сар бүрийн 05-ны дотор дүүргийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтэст хүргүүлсэн.	100
2.5.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт,		Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн	-Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Өмч хөрөнгө, эд аж ахуйн тооллого явуулах журам”, БГД нийгмийн даатгалын газрын даргын А/06 тушаалыг	100

	хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах.		захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна.	өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; -Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ (ТӨХ-1-с ТӨХ-11 маягт) болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх; -Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө,	үндэслэн тус газрын эд хөрөнгө, бараа материалын 2025 оны хагас болон бүтэн жилээр тооллогыг зохион байгуулж эд хөрөнгө, бараа материалын дутагдал илрээгүй тайланг, мөн хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглах хугацаа сунгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалтыг 2025.04.03-ны өдрийн №01/767, 2025.10.22-ны өдрийн №814 тоот албан бичгээр НДЕГ-т тус тус хүргүүлсэн. НДЕГ-ын даргын 2025 оны А/309 дүгээр тушаалаар олгосон шинэ тоног төхөөрөмжүүдийг байгууллагын данс тооцоонд бүртгэн авсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгө акталж данснаас хасах тухай шийдвэрээр 14 нэр төрлийн 34.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлээс хасч устгалд оруулсан.	
--	---	--	---	--	---	---	--

					маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх; -Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах; -Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” программд дараа оны 03 дугаар сарын 05-ны дотор оруулах; -Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна.		
2.6.	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас		Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг	а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн	а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын	Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн тайланд “Гэрэлтэх бүртгэл аудит” ХХК аудитын шалгалт хийгдсэн. Өнгөрсөн 2024 оны	100

	“Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.		хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100 хувь биелүүлсэн байна.	сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжөөр 4-5 жилийн насжилттай 33 харилцагчаас авах 159,349.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бүрэн барагдуулан 11 жилийн насжилттай ажилласан жил тооцох нөхөн даатгалын шимтгэлийн 203 хүнд өгөх 2,339.3 мянган төгрөгийн өглөгийг тодруулан буцаан олгох анхан шатны бүрдлийг ханган ажиллаж 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 203,614.0 төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүйг нөхөн мэдээллэж, ХХОАТ-ын 437.6 мянган төгрөгийн, НДШ-ийн 94.4 мянган төгрөгийн, нийт 532.0 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	
2.7.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх.		Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	а)Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б)Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжийг олгох, мөн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйлгээг шуурхай чирэгдэлгүй гүйцэтгэх зарчмыг баримтлан ажилласан. Тэтгэвэр тэтгэмж олгох, сангийн дансны үлдэгдлийг төвлөрүүлэх зэрэг олон ажлуудыг гэрээнд дурьдсан журмын дагуу хийж гүйцэтгэсэн. Нийгмийн даатгалын газрын хэмжээнд төрийн сан болон арилжааны 5 банкинд байршиж буй нийт 23 дансаар гүйлгээ хийгдэж, хамтран ажиллах гэрээний	100

						хэрэгжилтийг бүрэн хангаж, биелэлтийг НДЕГ-ын СБХОГ-т тогтоосон хугацаанд нь хүргүүлсэн.	
2.8.	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн тайланг шинэ хэрэгжиж байгаа “Sicos программ” дээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд даатгуулагчид, байцаагч ажилтануудад ямар нэгэн чирэгдэл учруулахгүй түргэн шуурхай ажиллаж хэвшсэн.	100
2.9.	Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх.		ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Sicos” програгмд оруулж, тайлан тооцоог гаргаж байна.	100
2.10.	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах.		Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан .	а)Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр	НДЕГ-ын даргын 2025.07.24-ний өдрийн А/204 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх тооны тайлан мэдээлэл судалгааны баримт бичгийн болон мэдээлэл лавлагааны баримт бичгийн маягтын жагсаалтыг нэг, хоёрдугаар хавсралтаар батлагдсаны	100

			баталгаажуулна.		бүрэн шинэчлэн баталгаажуулах. б)Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	дагуу бүртгэл хөтөлж ажилласан. Мөн Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан /НХМаягт Т-3/ тооцооны үлдэгдлийг баталгаа маягтуудаар тооцоог нийлж баталгаажуулан ажиллаж байна.	
Зорилт 2.1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүгээр хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1.1.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаардлагагүй	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2024 онд 14,484 хүнийг сайн дурын даатгалд, үүнээс 14 малчин хамруулав.	Сайн дурын даатгалд шинээр 2285 хүнийг шинээр хамруулж төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/38 тушаалаар салбарын хэмжээнд “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарлаж, энэхүү зорилтын хүрээнд хууль тогтоомжийн шинэчлэлийг сурталчилах, иргэд даатгуулагчидад сайн дурын даатгалын ач холбогдолыг таниулах, шинээр хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулж ажилласан. Энэ онд шинээр “Sicos программ”-ыг нэвтрүүлэн ажилласнаар сайн дурын даатгалд шинээр даатгуулсан болон гэрээ сунгалт хийлгэсэн 13895 даатгуулагчийн мэдээллийг программд шивж оруулан, 2296 даатгуулагчийг сайн дурын даатгалд шинээр хамруулж нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлсэн. Үүнээс энгийн сайн дурын даатгалын гэрээ 1801, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эх, эцгийн гэрээ 206, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эхийн гэрээ 284, малчин, туслах малчны 5 гэрээг тус тус шинээр бүртгэн сайн дурын даатгалд хамруулсан.	100

2.1.2.	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаардлагагүй	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2024 онд 8,571 ажил олгогч, 152,570 хүнийг албан журмын даатгалд хамруулав.	Ажил олгогчийн тоог шинээр 401, даатгуулагчийн тоог шинээр 2406 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Энэ онд нийгмийн даатгалд шинээр 875 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сар бүр хүлээж авч тооцоог тухай бүр хийн албан журмын даатгалд шинээр 2410 даатгуулагчдыг хамруулсан. Хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр дүүргийн нийгмийн даатгалын газрын пэйж хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд холбогдох хууль тогтоомжийг сурталчилан таниулах ажлыг хэрэгжүүлсэн.	
2.1.3.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 30-аас доошгүй хувиар бууруулах;	-	Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 59,469.2 сая төгрөгт хүрсэн.	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 59,469.2 сая төгрөгийг /2.1.4-д зааснаас бусад шимтгэлийн авлага/ бүрэн барагдуулах. Шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 тушаалаар батлагдсан журмын дагуу өр авлагыг насжилтаар нь ангилан барагдуулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд 176 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, 320 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлж, 3897 аж ахуйн нэгж байгууллагын дансанд барилт хийж, 224 аж ахуй нэгж байгууллагатай өр барагдуулах гэрээ байгуулж, 29 аж ахуй нэгж байгууллагыг шүүх, ШШГА-д шилжүүлэх арга хэмжээнүүдийг авч ажилласан. Албан шаардлага хүргүүлсэн ажил олгогчдийн өрнөөс 12,225.16 сая төгрөгийн, дансанд барилт хийсэн ажил олгогчдийн өрнөөс 22,459.54 сая төгрөгийн, уулзалт хийсэн ажил олгогчдийн өрнөөс 6,721.7 сая төгрөгийн, өр барагдуулах гэрээ байгуулсан ажил олгогчдийн өрнөөс 8,561.84 сая төгрөгийн, шүүх, ШШГА-нд албанд шилжүүлсэн ажил олгогчдийн өрнөөс 1,899.80 төгрөгийн өрийг тус тус барагдуулсан байна. 2025 оны эхний 11 сарын байлаар 59,469,42 сая төгрөгийн авлагаас	85

						34,479,12 сая төгрөгийн авлага буюу 58,0 хувийг барагдуулсан байна.	
2.1.4.	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх;		Шимтгэлийн өргүй гарсан байх.	Төсөвт байгууллагын шимтгэлийн өр 1,392.9 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 273.6 сая төгрөг байна.	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	Дүүргийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст 2025.06.23-ны өдрийн 484 тоот албан бичгээр тус газраас 26 төсөвт байгууллага нь 629,074,617.0 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулах чиглэлээр шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлэн өр барагдуулсан. Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газраас авах шимтгэлийн авлагын судалгааг хагас жилээр хүргүүлэн уулзалт хийн барагдуулах арга хэмжээ авч ажилласан. Энэ оны эхний 11 сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагуудын тооцоо, судалгааг гарган хүргүүлсэн.	90
2.1.5.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100 % хангуулна.	Нийгмийн даатгалын санд 477,744.2 сая төгрөгийн орлого хуримтлуулав.	Нийгмийн даатгалын санд 594,863.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ.	Энэ онд тус газар нь 2025 онд ажил олгогчоос албан журмын даатгалд 592,703,379.24 мянган төгрөг төвлөрүүлэхээс 534,025,744.69 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 90.1 хувиар биелүүлэн ажиллалаа.	100
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Зорилт 3: “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
3.1.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих;	-	- Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ.	Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаал, 2024 оны “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх зөвлөмж хүргүүлэх тухай” №01/899 дүгээр албан бичиг, 2025 оны “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах тухай” №02/259 тоот албан бичгүүдтэй тухай бүр танилцан,	100

					эрхийг хангаж ажилласан байна.	хэрэгжилтийг хангаж ажилласан. Байгууллагын цахим хуудсанд байршуулах нээлттэй мэдээллийн жагсаалт бүхий 48 заалтын дагуу мэдээллүүдийг улирал бүр шинэчлэн байршуулсан. Газрын даргын 2025 оны А/07 тоот тушаалаар мэдээлэл байршуулалтад хяналт тавих үүрэг бүхий ажилтныг шинээр томилон хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Байгууллагын нэгдүгээр давхрын угтах үйлчилгээний хэсэгт “Нээлттэй мэдээллийн ил тод байдал”-ын 16 төрлийн мэдээлэл агуулсан самбарыг байршуулан иргэдэд холбогдох эрх зүйн мэдлэгийг олгож байна.	
3.2.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих;	-	- Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. - Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна.	Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 85,7 хувьтай байна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Энэ онд үйл ажиллагааны орлого зардлын шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр хуулийн хугацаанд нь тайлагнаж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 171 мэдээллийн 5 бүлэг 29 зүйлийн мэдээллийг байгууллагын нягтлан бодогч, нийгмийн даатгалын сангийн 159 мэдээллийн 5 бүлэг 28 зүйлийн мэдээллийг сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн нар https://info.shilendans.gov.mn сайтад 7 хоног, сар, улирал, жилээр мэдээллийг байршуулан хяналт тавин ажилласан.	100
Зорилт 3.1: “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
3.1.1.	Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон	-	- Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь,	-	Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох	Газрын даргын 2025.02.20-ны өдрийн №01 тоот “Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийж, олголт шалгах” удирдамжийн хүрээнд нийт 36005 тэтгэврийн хувийн хэрэг тоологдохоос 35993 тоологдож, 12 хувийн хэрэг дутуу бүртгэлтэй байсныг шалгалтын хугацаанд	100

	газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах,		- Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь.		шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	олж тогтоон тооллогод хамруулсан. 2024 онд шилжиж явсан 154, нас барсан 541, зогсоогдсон 1127 нийт 1822 тэтгэвэр авагчийн олголтыг шалгасан. Үүнээс нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг 16 хүнд 30572727 сая төгрөг, шилжиж явсан өндөр насны 5 тэтгэвэр авагчдад 6604490 сая төгрөг, зогсоогдсон 12 тэтгэвэр авагчдад 6611672 төгрөгийг тус тус илүү олгосон зөрчил илэрснийг улсын байцаагчийн акт тогтоон барагдуулан ажиллаж байна. Тус газрын даргын 2025.05.15-ны өдөр баталсан “2024 онд ирүүлсэн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хяналт шалгалт хийх” №05 тоот удирдамжийн дагуу 8258 аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж буй эсэхэд хяналт шалгалт хийсэн. Хамралт орлогын хэлтэс нь 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 90.57 хувиар биелүүлж, нийт 8258 байгууллагын шимтгэл төлөгч албан журмын даатгалд хамрагдаж, 8215 байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан өгснөөс тайлан авалтын хувь 98,8 хувьтай байна. Шинээр 760 байгууллага шимтгэл төлөгчөөр нэмж бүртгүүлсэн, 26 байгууллага шилжсэн байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/99 дүгээр тушаал “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах баталгаажуулах журам”-ыг зөрчиж нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанаас хоцроосон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу 5 аж ахуйн нэгжид 1,2 сая төгрөгийн торгууль ногдуулан хариуцлага	
--	---	--	--	--	---	--	--

					тооцсон. 2024 онд 11 ажил олгогч, 19 даатгуулагч цалин өөрчлөх хүсэлт гаргаж, 5 даатгуулагчийн цалин устгаж залруулсан. Шалгалтаар: НД№7, НД№8 тайланг хэвлэмэл хэлбэрээр хүлээн авахдаа хариуцсан байцаагч хянаж, баталгаажуулсан огноо /он, сар, өдөр/ буюу тайлан ирүүлсэн, хүлээн авсан хугацааг бичдэггүй, ажил олгогч байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал дутуу, даатгуулагчдын ажил мэргэжлийн ангилал дутуу болон буруу, даатгуулагчдын төрөл кодын зөрчилтэй, байцаагчийн тамга тэмдэг, гарын үсгийн тайлал дутуу зэрэг зөрчил нийтлэг байна. Мөн 2023 оны шимтгэл төлөлтийн тайланд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн кодын зөрчлийг арилгаж, авч хэрэгжүүлсэн ажлын тайлан ирүүлэх тухай Улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн хариуг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, хяналтын хэлтэст ирүүлэхийг үүрэг даалгавар болгосон. Мөн 2024 онд нийгмийн даатгалын шимтгэл төлж тайлан өгсөн аж ахуйн нэгж байгууллагуудын хадгаламжийн нэгжийг архивд хүлээлгэн өгөөгүй зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж авч хэрэгжүүлсэн ажлын тайлан ирүүлэх хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлэн ажилласан. Газрын даргын 2025.06.03-ны өдрийн “Дотоодын хяналтыг сайжруулах” А/10 тоот тушаалын дагуу ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт, олголтод дотоодын хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 2023 онд 850 даатгуулагчид, 2024 онд 4311 даатгуулагчид олгосон ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолт, олголтыг мэдээллийн сан болон анхан шатны баримт материалд үндэслэн шүүж	
--	--	--	--	--	--	--

					үзэхэд 2023 онд 301 даатгуулагч, 2024 онд 421 даатгуулагчид илүү олгосон байх магадлалтай зөрчил илэрсэн тул ажилд орсон, гарсан тушаалын хуулбар болон санхүүгийн баримттай тулган баталгаажуулсан. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль”-ийг зөрчсөн 51 даатгуулагчид 86,038,791.46 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосныг илрүүлж, 2025.11.28-ны өдөр Улсын байцаагчийн “250256” тоот акт тогтоож шийдвэрлэсэн. Улсын байцаагчийн тогтоосон актын 30 хүний 41,338,347.04 төгрөгийг барагдуулсан. 2024 онд ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн зөрчилтэй байх магадлалтай 340, 2023 онд 301 даатгуулагчийн тушаалын хуулбарыг авч нягтлан шалгах ажил хийгдэж байна. Тус газраас 2021-2024 онд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 412 тэтгэвэр авагчийн ажилласан жил, цалин тодорхойлсон лавлагааны үндэслэлийг шалгасан. Шалгалтаар ахин тодруулах шаардлага бүхий 18 тэтгэвэр авагчийн лавлагааны үндэслэлийг дахин баталгаажуулсан. Үүнээс Архвын ерөнхий газар 1, Дархан-Уул аймгийн Архив 9, Увс аймгийн Архив 1, Ажил олгогчийн архив 7 байна. 2025 онд 643 ААНБ-аас ирүүлсэн албан бичиг, өргөдлийг шийдвэрлэн 1,535,718,923 тэрбум төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос 259,886,472 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, 123,725,429 сая төгрөгийн алданги ногдуулж, нийт 383,611,902 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож төлбөр зөрчлийг 100 хувь барагдуулан ажилласан.	
--	--	--	--	--	---	--

						Зөрчлийн тухай хуулийн 10.17.1,10.17.2, 10.17.5 дугаар заалтын дагуу хялбаржуулсан журмаар 35 аж ахуй нэгж байгууллагад 22,7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж БГД-н Прокурорын нэгдсэн бүртгэлд хугацаанд нь бүртгүүлж торгуулийг бүрэн барагдуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/206 тоот албан бичиг, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 19 ААНБ-д хяналт шалгалтыг хийж 191,098,142 зөрчил илрүүлэн улсын байцаагчийн акт тогтоож төлбөр зөрчлийг бүрэн барагдуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/47 тоот тушаалын дагуу нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 100,0 сая төгрөгөөс дээш шимтгэлийн өртэй, 271 ба түүнээс дээш хоногийн насжилттай хуримтлагдсан өр үүсгэсэн ажил олгогч байгууллагуудад зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр 100 сая төгрөгөөс дээш шимтгэлийн өр үүсгэсэн байгууллагуудын судалгааг ХОХ-ээс гаргуулж, авлага барагдуулах ажлын хэсгийг байгуулан 82 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон холбогдох санхүүгийн ажилтнуудтай уулзалт хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажилласнаар 52 байгууллагын 9,7 тэрбум төгрөгийг өр төлбөрийг барагдуулсан.	
3.1.2.	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж,	-	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025.02.14-ний өдрийн №01/336 тоот албан бичиг болон аж ахуйн нэгж байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж, тус газрын даргын	100

	байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;		ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд ыг шалгасан байна.		бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	2025.04.01-ний өдрийн №02 тоот удирдамжийн дагуу дүүргийн их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн нийт 19 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, 12 байгууллага 507,858,033 төгрөгийн цалингийн сангаас нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй зөрчил илэрсэн. Төлөгдөөгүй цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 115,125,604 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, 53,062,807 төгрөгийн алданги ногдуулсан. Шимтгэл, алданги нийлээд 168,188,411 төгрөгийн төлбөр зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийг 100 хувь барагдуулсан.	
3.1.3.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагууд ыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025.10.06-ны өдрийн №08/2504 тоот албан бичгээр тус газарт бүртгэлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгуулахаар 429 байгууллагын жагсаалтыг ирүүлсэн. НДЕГ-ын даргын 2025.02.14-ний өдөр баталсан аж ахуй нэгж, байгууллагыг шалгах нэгдсэн удирдамжид заасан чиглэлээр хяналт шалгалтын 4 байцаагч 2 багт хуваагдан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025.10.06-ны өдрийн №08/2504 тоот албан бичгийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор шалгалтын дүн, тайланг хүргүүлж ажиллана.	30

3.1.4.	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	-Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь -Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, -Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	-	Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна.	Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2024 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 2 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мөн оны “Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай А/78 дугаар тушаал, Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны №08-07/06 дугаартай “Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж”-ийн дагуу Баянзүрх, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2022-2024 оны ажилгүйдлийн даатгалын сангийн нийт 24900 даатгуулагчид 117,132.4 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тогтоож олгосон байна. Үүнээс: Түүврийн аргаар нийт даатгуулагчдын 19.0 хувь буюу 4734 даатгуулагчийн тэтгэмж олголтын хувийн хэрэг, санхүүгийн баримтад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын явцад 15 даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон зөрчилд 15,709.0 мянган төгрөгийг санд буцаан төвлөрүүлэх улсын байцаагчийн 4 заалт бүхий 2 акт тогтоож, ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж албан журмаар шимтгэл төлсөн нийт 107 даатгуулагчид илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төвлөрүүлэх улсын байцаагчийн 3 заалт бүхий 2 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан.	100
3.1.5.	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,	2024 онд 15 объектод хяналт шалгалт хийж, 10 заалт бүхий албан шаардлага хүргүүлж ажилласан.	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2024 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай”, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мөн оны “Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай А/78 дугаар тушаалыг тус тус үндэслэн Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 онд хийгдэх төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн	100

			-Удирдамжийн хугацаанд мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.			хүрээнд дүүргийн 15 аж ахуй нэгж байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөсөнөөс ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нартай хамтарсан хяналт шалгалтаар цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх түгээх дамжуулах үйл ажиллагаа эрхэлж буй 1 аж ахуй нэгж байгууллагын 1644 иргэнд холбогдох баримт материалыг шалгаж 3 зөрчилд улсын байцаагчийн 3 заалт бүхий 1 албан шаардлага, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй 11 аж ахуй нэгж байгууллагын 1196 иргэнд холбогдох баримт материалыг шалгаж 27 зөрчилд 10 аж ахуй нэгж байгууллагад улсын байцаагчийн 27 заалт бүхий 10 албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэлийн шалгалтаар зөрчлийг арилгуулж, 80 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.	
3.1.6.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх,	-	-Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалты н хувь, - НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо,	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т хүргүүлж ажилласан.	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр днг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	Монгол улсын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2024 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 2 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай А/78 дугаар тушаал, Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025.01.07-ны өдрийн 08-07/06 дугаартай “Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж”-ийн дагуу ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт зарцуулалтад хяналт шалгалтын ажлыг энэ оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Шалгалтаар 7 иргэнд 40,369,691 төгрөг илүү олгосон, 1 иргэнд 844,875 төгрөг дутуу олгосон зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 2025.05.30-ны өдрийн СХ-32/00005 тоот улсын байцаагчийн акт тогтоосон. Шалгалтаар илэрсэн зөрчлийг барагдуулах арга	100

						хэмжээг шуурхай зохион байгуулж ажилласнаар төлбөр зөрчлийн 60 хувийг барагдуулсан. Хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, судалгааг хүснэгтээр гарган шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.	
3.1.7.	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	-	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах,	Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрлийн барагдуулалтад хяналт тавьж ажилласан.	Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Дотоодын хяналт шалгалтын тайланг улирал тутам гарган сангийн тайлантай тулгалт хийн баталгаажуулж, хагас бүтэн жилийн тайланг нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, хуулийн хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.	100

Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.

Зорилт 4: “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.1.	Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх;		-06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. -Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн	2024 онд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, биелэлтийг нэгтгэн авч, дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 89,4%-тай хэрэгжсэн байна.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой дээд шатны байгууллагаас гаргасан 11 тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тооцон биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Тус газрын даргын А тушаал 12, Б тушаал 102 гарсныг алба хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын дотоод ажлын хуваарийг боловсруулан баталж, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, цаг үеийн шинжтэй дээд газраас ирүүлсэн судалгаа, тайлан мэдээг тухай бүрд нь түргэн	100
------	--	--	--	--	--	--	-----

						шуурхай хүргүүлэх тал дээр албан хаагчдыг багийн зохион байгуулалтад оруулж ажилласнаар дээд шатны байгууллагад илгээж байгаа баримт бичгийг цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.	
4.2	Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;		-Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ. -Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2024 онд 98%-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна.	Иргэн, аж ахуй нэгж, байгууллага даатгуулагдаас энэ онд 559 өргөдөл, гомдлыг хүлээн авснаас 538-г хуулийн хугацаанд шийдвэрлэж, ажиллагаанд байгаа 20, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1 байгаагаас гомдол 41, хүсэлт 517, талархал 8 байна. Үүнээс бичгээр 516, Засгийн газрын 11-11 төвөөс 40, 1800-1200 дугаараас 3 тус тус байна Шийдвэрлэлтийн дундаж хугацааны индекс 0.94 байна. Өргөдөл, гомдлыг агуулгаар нь авч үзэхэд тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой 87, сайн дурын даатгалтай холбоотой 36, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой 221, шилжүүлэг залруулахтай холбоотой 95, ажилгүйдлийн даатгалтай холбоотой 20, бусад 100 байна.	100
4.3.	Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх;		Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна.	Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор ханган ажилласан.	Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргах, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр тайлагнасан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан бүтэц зохион байгуулалтаар тус газар нь нийт 58 орон тоотойгоор батлагдснаас 1 байцаагчийн орон тоо сул байна. Сар бүр орон тооны мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тайлагнасан. Мөн газрын хүний нөөцийн үндсэн болон цалин хөлсний мэдээллүүд, шилжилт хөдөлгөөнийг Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим систем, байгууллагын удирдлагын цогц программ хангамж болох “Able”, Нийслэлийн захиргааны байгууллагуудын “UB-ERP” цахим систем, Нийгмийн даатгалын салбарын “GREEN ERP” системүүдэд тухай бүр	100

						хийж байцаагч, ажилтнуудын албан хэрэг хөтлөх, цалин хөлс авах, хянах боломжуудыг ханган ажилласан. Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хуулийн дагуу хэрэгжүүлэн, хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг хангах чиглэлийг удирдлага болгон ажиллаж байна. Энэ онд 5 гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлд хүргүүлж ажилласан.	
4.4.	Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх;		Холбогдох судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна.	Цаг хугацаанд нь үнэн зөв гаргах.	Судалгааг үнэн зөв гаргаж холбогдох баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Тус газрын албан хаагчдын нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, төрийн захиргааны албан хаагчид олгох зэрэг дэвийн нэмэгдэл болон бусад судалгааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гарган НДЕГ-т хүргүүлсэн. ГБХНХ-ын сайдын 2025 оны А/16, А/137 тушаалын дагуу төрийн захиргааны 15 албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон.	100
4.5.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;		Хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлсэн.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны дэд төлөвлөгөөг баталж, газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж ирүүлээгүй болно.	Үнэлэх боломжгүй
4.6.	Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн		Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна.	Салбарын хэмжээнд 100 хувь ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж	Авлигын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	2024 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах ТЗ-7 болон түүнээс дээш ангилал, зэрэглэлд ажилладаг 42 албан тушаалтнуудаас ХАСХОМ-ийг цахимаар авч,	100

	даатгалын ерөнхий газарт хүргүүлэх;			холбогдох газарт хүргүүлсэн.		баталгаажилтын хуудсаар бүртгэл хөтлөн ХОМ-1, ХОМ-2, ХОМ-3, ХОМ-4 тайлангуудыг нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлсэн. Шинээр томилогдсон болон албан тушаалын чиг үүрэг өөрчлөгдсөн 13 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулж, холбогдох тушаал, шийдвэрийг гаргасан байна.	
4.7.	2024 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх;		Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна.	-	Судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлнэ.	Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний болон захиргааны хэргийн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүхийн тогтоол, шийдвэр, магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол зэрэг 31 шийдвэрийг гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хуулийн хэлтэст файлаар хүргүүлсэн.	100
4.8.	Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах;		-Хугацаанд нь хүргүүлэх, -Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 75%-тай байв.	Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаас энэ онд үүрэг, албан даалгавар, дүүргийн ЗДТГ-аас үүрэг, даалгавар, ажлын чиглэл тус бүр 1, захирамж 2, санал 2, хугацаатай албан бичиг 11 ирүүлснээс тухай бүр тогтоосон хугацаанд нь биелэлтийг тооцон хүргүүлсэн. Тус газрын даргаас энэ онд удирдлага зохион байгуулалтын шинжтэй 5 үүрэг, ажлын чиглэл өгч, хэрэгжилтийг тухай бүрт танилцуулж ажилласан.	100
Зорилт 4.1: “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.1.1.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан		-Авлигаас урьдчилан сэргийлэх 2	Газрын ажилтнуудад авлигын тухай,	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг,	Тус газрын ажилтан, албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, авлига, ашиг сонирхлын	100

	сэргийлэх сургалтыг байгуулах;	талаарх зохион		удаагийн сургалт зохион байгуулах, -Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна.	нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээ авах зорилгоор энэ оны 05 дугаар сард “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалт”-ыг Авлигатай тэмцэх газар, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлтэй хамтран зохион байгуулж, Эрүүл мэндийн магадлалын гишүүд бүрэн хамрагдсан. Мөн Авлигатай тэмцэх газрын цахим хуудсаар дамжуулан сургалт авах хүсэлт илгээн 06 дугаар сард “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад тус газрын 45 байцаагчийг хамруулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. Авлигатай тэмцэх газарт хүсэлт хүргүүлсэнээр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Ариунзаяа “Авлигын хэлбэр, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт 2 цагийн сургалтыг ажилтан, албан хаагчдад мэдээлэл хийж, харилцан мэдээлэл солилцсон.	
4.1.2.	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;		-Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, -Албан хаагчдыг 100% хамруулсан байна.	Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 10 удаагийн сургалтад 620 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна.	Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 25 удаагийн сургалтад 1120 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулсан. Үүнд: “Үндэсний бичиг”, “Ажлын байран дахь стресс, түүнийг даван туулах арга зам”, “Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага”, “Нурууны суулт түүнээс урьдчилан сэргийлэх”, “AI /Хиймэл оюун ухаан/ хэрхэн ашиглах, албан хэрэгцээнд хослуулан ашиглах нь”, “SICOS программын шинэчлэл, түүний хэрэглээ”, “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”.	100	

						“Авлига, авлигын шалтгаан, хор хөнөөл”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, тэтгэврийн тусгай зохицуулалт, тэтгэвэр бодох аргачлал”, “Улсын байцаагчын шалгалтын зөвлөгөө анхаарах зүйлс” зэрэг сэдвүүдээр сургалт оруулж, алба хаагч, ажилтны мэдлэгийг дээшлүүлсэн. Долоо хоног бүрийн пүрэв гаригт алба хаагч, ажилтны ажлын байрны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо сургалт мэдээллийг тогтмол хийх ажлыг хэвшил болгосон.	
4.1.3.	Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;		-Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, -30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, -Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 9 удаагийн сургалтад 9 аж ахуйн нэгжийн 700 гаруй иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулав.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 20 удаагийн сургалтад 20 аж ахуйн нэгжийн 2635 гаруй иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулсан. Тухайлбал: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 09/19 дугаар удирдамжийн дагуу 02 дугаар сард дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд дахин магадлал хийгдэж, гарсан дүгнэлт, зөвлөмжийг тус төвийн эмч, удирдлагуудад танилцуулж цаашид авах арга хэмжээний талаар зөвшилцөн, сургалт зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, ХХҮХэлтэс, ЭМТөвтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих, хамтран ажиллах” нээлттэй хаалганы өдөрлөгийг 05 дугаар сард өдөр зохион байгуулж, өдөрлөгт 500 орчим иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгсөн. Энэ оны 04 дүгээр сард дүүргээс “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аян-2025” өдөрлөгийг зохион байгуулж, уг арга хэмжээнд тус газраас “Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай”	100

					сэдвээр илтгэл тавьж, хууль тогтоомжийг сурталчлан, мэдээлэл хүргэж оролцсон. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 02, 05, 09 дүгээр сард зохион байгуулсан Хүүхэд, гэр бүл, хамгааллын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, 34 хороодын Засаг дарга, ажлын алба, хорооны нийгмийн ажилтан нарт, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих, хамтран ажиллах” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон 200 орчим иргэн даатгуулагчдад, “Ахмад настныг дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” сэдэвт арга хэмжээнд 34 хороодын 1500 гаруй ахмад настанд тус газраас оролцож, холбогдох хууль тогтоомжийг сурталчилах, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. “Итгэлцлийн аян”-ны хүрээнд 75 ажил олгогчийн захирал, санхүүгийн ажилтан, хүний нөөцийн мэргэжилтэнүүдэд тус газрын хурлын танхимд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, ажил олгогч даатгуулагчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор сургалт зохион байгуулсан. Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжуудыг сурталчлах зорилгоор “Хүннү мебель”, “Мандах их сургууль”, “ОСНААУГ ХҮТ-9”, “ОСНААУГ Хэрэглэгчдэд үйлчлэх төв” УБТЗ-ын “зорчигчийн вагон депо, татах хэсэг”, “дулааны iv цахилгаан станц” ТӨХК, “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ, “Ази фарма мед” ХХК, “Макс групп”, “Үндэсний техникийн их сургууль” зэрэг байгууллагуудад сургалт зохион байгуулж, 1300 иргэд даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгсөн.	
--	--	--	--	--	--	--

Зорилт 4.2: “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.2.1.	Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах;	-	Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна.	Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан.	Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. Үйлчилгээний орчны нөхцлийг сайжруулах, хүлээлгийн өрөөг засаж тохижуулах, Газрын барилгын хэвийн үйл ажиллагааг хангах, цахилгааны засвар, тоног төхөөрмжийн шинэчлэл хийх	НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөн ажилласан. Тус газраар үйлчлүүлж буй иргэд даатгуулагчдад тав тухтай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийн үүдний хүлээлгийн танхимын хэсгийг засаж тохижуулан тусгай хэрэгцээт иргэдэд чиглүүлэх зам, хонх, ариун цэврийн өрөө, тусгай үйлчлэх цонх, мэдээллээр хангах дэлгэц байршуулснаар иргэд даатгуулагчдыг тав тухтай үйлчлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.	100
4.2.2.	“Цахим архив”-ыг үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	-	Тэтгэврийн хувийн хэргүүдийг цахимжуулсан байна.	-	Иргэд даатгуулагчдад чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх зорилгоор цахимаар архивын үйлчилгээ, ажилласан жил, шимтгэл төлсөн лавлагаа, тэтгэврийн хувийн хэрэг зэрэг олон төрлийн	Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх зорилгоор цахимаар тэтгэмжийн /ЖА, ХЧТүр алдалт, ажилгүйдэл, ҮОМШӨ ХЧТүр алдалт/ материалыг хүлээн авч, шинээр тэтгэвэр тогтоолгож буй 1140 даатгаагуулагчийн анхан шатны материалыг цахимжуулсан.	100

					үйлчилгээг шуурхай авах боломжтой болно.		
4.2.3.	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;	-	Дуудлага алдалт 15%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна	Ирсэн дуудлага 60548, дуудлага алдалт дунджаар 58 %.	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна.	Байгууллагын ашиглаж буй үйлчилгээний /callpro/ 7200-1289 / 501, 502, 503, 504, 505/ дугааруудын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байгаа бөгөөд нийт 4 удаагийн сүлжээний гэмтэл гарч, асуудал үүссэнийг “Каллпро” компанид цахим хүсэлт болон 7272-7070 дугаарын утсаар холбогдон хэвийн үйл ажиллагааг хангуулсан. Энэ онд иргэд, даатгуулагчдаас 94,045 дуудлага хүлээн авч, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.	100
4.2.4.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах;	-	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг - “Рийл” улиралд 3-аас доошгүй удаа; - “Постер” сард 3-аас доошгүй удаа; - “Видео контент” улиралд 1 удаа; - Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа;	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна.	Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлтүүдийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчлах олон талт ажлыг зохион байгуулсан. Үүнд: Нийгмийн даатгалын хууль тогтоомж, шинэчлэл, үзүүлж буй үйлчилгээ, газрын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой 70 постер, 28 видео контент, мэдээ, мэдээллийг газрын албан ёсны фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн. ГБХНХЯам, АТГ, НДЕГ-ын болон бусад газраас нийгмийн даатгалын хууль тогтоомжтой холбоотой ирүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүрд нь газрын пэйж хуудас болон байцаагч, ажилтнуудын фейсбүүкээр дамжуулан олон нийтэд түгээн сурталчилах ажлыг зохион байгуулж, МҮОНР, UBS телевизүүдээр 4 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэн 6 удаагийн давтамжтай, С1 телевизээр 1 удаагийн мэдээ бэлтгэн 2 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж, нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж ажилласан.	100

Зорилт 4.3: “Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.3.1.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх		Ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, удирдамж, тайлан	2024 онд 1 удаа зохион байгуулсан байна. 2024 онд 1-4 удаа зохион байгуулсан.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт болон магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах зорилгоор нийслэлийн 6 дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ижил мэргэжилтний үзлэгийг 06 дугаар сард Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын хурлын танхимд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд тус дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн Магадлагч эмч, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэжлийн 3 эмч, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Газрын даргын 2025.09.30-ны өдрийн №09/2441 тоот удирдамжмйн дагуу 11 дүгээр сард Дундговь аймагтай ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж ажилласан.	100
			Дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан		Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд сар бүр хяналт тавьж, цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн байгууллагаас тэтгэвэр авагчдын бүртгэлтэй тулган	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд сар бүр хяналт тавьж, цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн байгууллагаас тэтгэвэр авагчдын бүртгэлтэй тулган шалгах ажлыг зохион байгуулан ажиллалаа.	100

					шалгах ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, зөрчлийг арилгаж ажилласан байна.		
4.3.2.	Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх		Хийсэн судалгаа, дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан		Аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд хийсэн судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран тодорхой арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна.	Баянгол дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон иргэдийн тоо программд 5562 иргэн, дүүргийн нийт хүн амын тоотой (252979) харьцуулбал хүн амын 2,1 хувийг эзэлж байна. Тус дүүрэгт дотор, мэдрэл, чих хамар хоолой, нүд, гэмтэл, мэс заслын /хавдар/ эмгэгүүд эхний 6 байрыг эзэлж байгаа бөгөөд эдгээр нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 21,3 хувийг эзэлж байгаа бөгөөд тэргүүлэгч 5 өвчлөлийг дүүргийн эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулсан судалгаа хийж, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалт нь улсын дунджаас доогуур нийт хүн амынхаа 2,1 хувийг эзэлж байна.	100
			Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн хадгалалт, эмх цэгцийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан		Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичиг /амбулаторийн карт, рентгент зураг, CD, DVD зэрэг/-ийн эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж,	Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн хадгалалт, эмх цэгцийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хороодын эмч нартай хамтарч ажилласан. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дахин магадлалаар Эмнэлгийн хувийн хэргийн эмх цэгц, хадгалалт хамгаалалт болон хөтлөлт хангалттай сайн гэсэн үнэлгээ авсан. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлүүлж буй иргэдийн амбулаторийн карт дахь үечилсэн дүгнэлтэд өвчний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, өвчний үе шат, явц, хийгдсэн эмчилгээ,	100

					үр дүнд хүрсэн байна.	түүний үр дүн болон биеийн байдлын талаар дэлгэрэнгүй бичиж хэвшсэн. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн төлөвлөгөөг жил бүр батлуулж, гишүүн бүрд тодорхой арга хэмжээг хариуцуулан үр дүнг тооцож ажилласан.	
4.3.3.	Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах		Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан	2024 онд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан	Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.	Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/177, А/433 тоот хамтарсан тушаалыг үндэслэн энэ онд хөдөлмөрийн чадвар түр алдалт болон жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг цаг алдалгүй хянаж, иргэд датгуулагчид хүргэж байна. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/441, А/192 тоот хамтарсан тушаалыг үндэслэн Эрүүл Мэндийн Магадлалын Зөвлөл нь иргэн (даатгуулагч)-ийн бичиг баримтад үндэслэн 43 удаа хуралдан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, сунгаж, цуцалж шийдвэрэлснээс 546 иргэнд шинээр тогтоож, 546 иргэнд шинээр тогтоож, 2037 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 307 иргэнийг цуцалж, шилжиж явсан 3 иргэн, шилжиж ирсэн 15 иргэн, нас барсан 4 иргэн байна. ЭММЗ-ийн мэдээллийн сангийн мэдээлэлд дотоод хяналт хийсэн.	100
			Сургалт, өдөрлөг, цахим сурталчилгааны тоо, мэдээлэл авсан иргэдийн тоо, тайлан	2024 онд 3-аас доошгүй удаагийн сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл өгсөн	Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдтэй хамтран эрүүл мэндийн магадлалын талаар ерөнхий мэдээлэл өгч, иргэдэд эрүүл амьдралын хэв	Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт харьяалагддаг Эрүүл мэндийн байгууллагуудад хөдөлмөрийн чадвар алдалтаар эмнэлгийн хуудас бичиж, олгох журмаар сургалт зохион байгуулж, сургалтад Улсын 3-р төв эмнэлэг, Эх нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн дүн бүртгэгч эмч, Төмөр замын эмнэлгийн эмч нар, Эрүүл мэндийн 7-р төвийн нарийн мэргэжлийн эмч нар, 34 өрхийн	100

					маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, сурталчилгаа хийж мэдээллээр хангасан байна.	эрүүл мэндийн төвийн дарга нар оролцсон. Мөн тус дүүргийн 5562 иргэн /даатгуулагч/-н хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн даатгуулагчийн эрхийг хамгаалах, хангахын тулд мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг бий болгох, холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцох нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгт дүүргийн Нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж, MYOHP, UBS телевизээр 1 удаагийн мэдээ бэлтгэн 3 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж, олон нийтийг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.	
4.3.4.	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах		Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо	2024 онд 5 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 4 судалгаа хийж тайланг Төв зөвлөлд хүргүүлэн ажилласан	Дээд газраас өгсөн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 22 чиглэл, зөвлөмж, албан даалгавар ирж хариутай бичиг болон судалгааг хугацаанд нь хүргүүлсэн.	100
Зорилт 4.4: “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.4.1.	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх;		Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна.	Нийт бүртгэлтэй 12218 ажил олгогчийн үндсэн мэдээлэл буюу ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр, ажил олгогчийн дугаарыг бүрэн бүрдүүлж, өөрчлөлтийг мэдээллийн санд тухай бүр бүртгэн ажилласан.	100

			Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх		- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна. Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна.	Дүүргийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж эрхэлдэг 8127 ажил олгогчийн 141,588 даатгуулагчийн үндсэн мэдээлэл, даатгуулагчийн төрөл, улсын кодыг үнэн зөв хүлээн авч шийдвэрлэсэн.	
4.4.2.	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх;		Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.	Албан журмын болон сайн дурын даатгал давхардуулан төлсөн 325 даатгуулагчийн мэдээллийг шалган тухай бүрт залруулгыг хийж бүртгэлд оруулсан. “Sicos программ”-ыг нэвтрүүлснээр сайн дурын даатгалд шинээр даатгуулсан болон гэрээ сунгалт хийлгэсэн нийт 13895 гаруй даатгуулагчийн мэдээллийг программд бүртгэсэн байна.	100

			Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх		Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна.	Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх талаар анхаарч ажилласан.	
4.4.3.	Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах;		Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах		Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.	Нэгжид ашиглагдаж буй https://sicos.ndaatgal.mn программд шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухай бүрд нь хийж, байцаагч, ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Тэтгэвэр олголтын нэгдсэн файлыг 5 арилжааны банканд тайлант хугацаанд 12 удаа илгээж тэтгэврийг цаг хугацаанд нь олгосон. Нэг цэгийн үйлчилгээний байцаагч 5, хамралт, орлого шимтгэлийн байцаагч 4, сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн 6 нийт 24 компьютерын үйлдлийн систем болон хэрэглээний программуудын лицензийг сунган ажилласан. Мөн шинээр хүлээн авсан 12 компьютерыг байцаагч нарт сурьлуулан хэвийн үйл ажиллагааг хангасан.	100
			МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх		МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.	Шинээр ажилд орсон болон шилжсэн, ажлаас гарсан байцаагч нарын хэрэглэгчийн нууц үг, нэвтрэх нэрийг бүртгэсэн, шимтгэл, тэтгэвэр, тэтгэмжийн программуудын нууц үг, нэвтрэх нэрийг сольж ажилласан. https://sicos.ndaatgal.mn бүх байцаагч нарт шинээр эрх нээсэн. МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу болон судалгааг тухай бүрд нь хүргүүлэн ажилласан.	100
Нийт ажил, арга хэмжээ-49 100 хувьтай-45 90 хувьтай-1 85 хувьтай-1 30 хувьтай-1 Үнэлэх боломжгүй-1							

Ерөнхий үнэлгээ-98.02

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох;	Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна. -Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна.	Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна	Үндэсний бичигт хөрвүүлэх, Албан хэрэг хөтлөх	Баянгол дүүргийн “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан Үндэсний бичгийн сургалтыг 7 хоногт 2 удаа танхимаар зохион байгуулж байна. Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “.....төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэрэгээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэж заасны дагуу албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулж байна.	2025.01.02-2025.12.01	100
2	Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд хамрагдах;	Сургалт, зөвлөгөөнд бүрэн хамрагдсан байна.	Удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнд 2 удаа хамрагдсан.	Зохион байгуулагдсан хугацаанд	Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны 5 удаагийн сургалт, зөвлөгөөнд хамрагдсан.	2025.01.02-2025.12.01	100

3	Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах;	Удирдлагын манлайллын ур чадварын өнөөгийн түвшингээ тодорхойлж, хувь хүний манлайлах ур чадвараа ахиулах сургалтад 1-ээс доошгүй удаа хамрагдана.	-	Тухай бүр	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газраас 03 дугаар сарын 10-ны өдөр удирдах албан тушаалтнуудыг чадавхижуулах 8 цагийн хөтөлбөрт сургалтад хамрагдаж, байгууллагын манлайллыг сайжруулах, стратегийн төлөвлөлт хийх, хүний нөөцийн үр ашигтай менежмент хэрэгжүүлэх, багийг үр дүнтэй удирдах, шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр онол, практикийн мэдлэг олж авлаа. Мөн хамт олны уялдаа холбоог сайжруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх арга зүйг судалж, ажил хэрэгтээ хэрэгжүүлэх боломжтой чухал туршлага хуримтлуулсан.	2025.01.02-2025.12.01	100
4	Компанийн засаглалын сургалтад хамрагдах;	Удирдлагын ур чадвар, эрх зүйн ойлголт, гүйцэтгэх удирдлага, хариуцлагатай ажилтан, хувь хүний талаар мэдээлэлтэй болсон байна.		Тухай бүр	Энэ оны 04 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд Нийгмийн даатгалын газрын дарга нар “Хувь хүний хөгжил, манлайлал”, “Компанийн засаглал” сэдэвт сургалтад танхимаар хамрагдаж, байгууллагын засаглалын бүтцийг сайжруулах, эрх мэдэл, үүрэг хариуцлагын харилцааг тодорхой болгох, үр нөлөөтэй	2025.01.02-2025.12.01	100

					удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулахуйц ач холбогдолтой мэдээллүүдийг олж авсан.		
--	--	--	--	--	---	--	--

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР